

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/70/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай хот
2024 он

Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-undraaD@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn

Аудитор: Г.Баасанжаргал
Утас: 99032514
Цахим хаяг: BaasanjargalG@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.5.3 Нэмэлт төсөв	13
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	13
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	0

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.19 № 54

танай _____ -ны № _____ -т

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.РЕНЧИНСАМБУУ-Д

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь төсвөөс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 2,182,436 төгрөг олгосон, нутгийн зөвлөлийн уулзалт, золголтод 5,000,000 төгрөгийн хүнсний материал худалдан авсан, техникийн комиссын дүгнэлтгүй 4,750,000 төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан, аймгийн 100 жилийн ойд хандив өгсөн хүмүүст гарын бэлэг, дурсгалын зүйл 1,899,000 төгрөгөөр худалдан авч өгсөн зэрэг зориулалт бус зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-д "Хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 5.2-д "Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна", 7.1-д "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 15,367,980 төгрөгийн хөрөнгө худалдан авч, 43,042,500 төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар эрх бүхий байгууллагын шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжиж ирсэн сумын төвийн гэрэлтүүлгийн ажлын гэрээ хугацаандаа хийгдээгүй, тайлант онд 20,000,000 төгрөгийн ажил хийгдсэн ч тодорхой үр дүн гараагүй, Галуутайн голын гүүрний далан засах ажилд шууд гэрээ байгуулан 14,000,000 төгрөгийг гэрээлэгчийн хувийн дансанд шилжүүлсэн ч холбогдох анхан шатны баримтгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь хандиваар ирсэн үндсэн хөрөнгийг 9,951,000 төгрөгөөр илүү дүнгээр бүртгэсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 7,730,000 төгрөгийн мөнгөн гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй зэрэг алдаа гаргасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>/ төгрөгөөр /</i>			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,491,516.20	36,446,104.13
33	АВЛАГА	0	421,687.93
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	421,687.93
35	БАРАА МАТЕРИАЛ	34,491,516.20	36,024,416.20
35400	Хангамжийн материал	31,291,516.20	32,824,416.20
35410	Бичиг хэргийн материал	2,472,975.00	2,641,375.00
35420	Аж ахуйн материал	23,931,091.20	25,266,591.20
35430	Сэлбэг хэрэгсэл	3,779,450.00	3,779,450.00
35450	Барилгын засварын материал	598,000.00	627,000.00
35470	Бусад хангамжийн материал	510,000.00	510,000.00
35600	Мал амьтад	3,200,000.00	3,200,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	619,132,644.68	621,216,937.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	619,132,644.68	621,216,937.10
39200	Биет хөрөнгө	617,254,269.68	619,751,062.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	618,123,681.00	618,123,681.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-150,332,106.38	-175,567,880.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	153,384,800.00	156,584,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-112,162,950.70	-121,032,088.53
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	66,528,119.40	118,179,599.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,752,790.98	-56,086,624.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,147,780.00	25,147,780.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,307,187.57	-22,436,787.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	152,541,410.00	156,100,410.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-71,006,435.09	-81,351,776.95
39217	Ном	2,089,950.00	2,089,950.00
39300	Биет бус хөрөнгө	1,878,375.00	1,465,875.00
39301	Програм хангамж	2,802,000.00	2,802,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,217,625.00	-2,630,125.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,294,000.00	1,294,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	653,624,160.88	657,663,041.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,153.82	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,153.82	0
41300	Өглөг	25,153.82	0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	25,153.82	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	653,599,007.06	657,663,041.23
51	Засгийн газрын хувь оролцоо	653,599,007.06	657,663,041.23
51100	Засгийн газрын оруулсан капитал	331,501,291.24	331,501,291.24
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	331,501,291.24	331,501,291.24
51200	Хуримтлагдсан үр дүн	102,566,144.67	106,630,178.84
51210	Өмнөх үеийн үр дүн	110,765,832.79	102,566,144.67
51220	Тайлант үеийн үр дүн	-8,199,688.12	4,064,034.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,531,571.15	219,531,571.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	653,624,160.88	657,663,041.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	386,974,700.00	105,506,971.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,098,500.00	43,818,920.00
120	Нийтлэг татварын бус орлого	60,098,500.00	43,818,920.00
120009	Бусад орлого	314,500.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	54,000,000.00	43,042,420.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,784,000.00	776,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	326,876,200.00	61,688,051.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,068,000.00	61,688,051.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,068,000.00	61,688,051.60
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	308,808,200.00	0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,808,200.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	393,458,313.48	570,785,035.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,458,313.48	570,785,035.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,920,067.07	550,457,596.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,911,146.98	311,610,100.03
210101	Үндсэн цалин	178,111,175.58	227,939,686.20
210102	Нэмэгдэл	30,799,971.40	83,225,406.83
210104	Урамшуулал	0	445,007.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,245,246.00	64,308,045.57
210201	Тэтгэврийн даатгал	21,075,007.85	44,834,869.44
210202	Тэтгэмжийн даатгал	1,605,817.32	5,115,632.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,296,253.83	3,858,745.79
210204	Ажилгүйдлийн даатгал	298,014.97	851,621.49
210205	Эрүүл мэндийн даатгал	2,970,152.03	9,647,176.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,734,400.39	27,034,330.92
210301	Гэрэл, цахилгаан	2,263,991.79	2,761,394.92
210302	Түлш, халаалт	26,470,408.60	24,272,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,158,950.20	21,561,939.26
210401	Бичиг хэрэг	2,058,960.00	2,839,600.00
210402	Тээвэр, шатахуун	12,206,990.20	16,558,339.26
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	893,000.00	2,164,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,558,500.00	2,947,300.00
210604	Урсгал засвар	1,558,500.00	2,947,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,674,000.00	4,754,000.00
210702	Дотоод албан томилолт	1,674,000.00	4,754,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,035,218.00	70,474.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	503,800.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	234,450.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,148.00	48,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	0
210807	Газрын төлбөр	23,820.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,602,605.50	118,171,406.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,134,801.96	61,695,298.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	170,000.00	150,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,297,803.54	56,326,107.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,538,246.41	20,327,439.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,538,246.41	20,327,439.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,038,246.41	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,500,000.00	20,327,439.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-6,483,613.48	-465,278,064.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,716,074.64	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	351,899.64	0
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,364,175.00	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-8,199,688.12	-465,278,064.10

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	327,190,700.00	61,806,051.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	314,500.00	118,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	314,500.00	118,000.00
120009	Бусад орлого	314,500.00	118,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	326,876,200.00	61,688,051.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,068,000.00	61,688,051.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,068,000.00	61,688,051.60
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	308,808,200.00	0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,808,200.00	0

/ төгрөгөөр /

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	327,190,700.00	515,780,169.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327,190,700.00	515,780,169.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	320,652,453.59	495,452,730.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,809,176.20	332,911,187.35
210101	Үндсэн цалин	182,009,204.80	241,434,621.37
210102	Нэмэгдэл	30,799,971.40	91,031,558.98
210104	Урамшуулал	0	445,007.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,278,699.00	43,453,800.00
210201	Тэтгэврийн даатгал	17,108,460.85	29,548,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,566,817.32	3,476,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,257,253.83	2,781,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	298,014.97	695,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,048,152.03	6,952,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,734,400.39	28,234,330.92
210301	Гэрэл, цахилгаан	2,263,991.79	2,761,394.92
210302	Түлш, халаалт	26,470,408.60	25,472,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,101,260.00	19,918,840.00
210401	Бичиг хэрэг	2,058,960.00	2,636,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,149,300.00	15,118,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	893,000.00	2,164,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,763,000.00	2,024,900.00
210604	Урсгал засвар	1,763,000.00	2,024,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,674,000.00	4,512,000.00
210702	Дотоод албан томилолт	1,674,000.00	4,512,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,035,218.00	70,474.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	503,800.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	234,450.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,148.00	48,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	0
210807	Газрын төлбөр	23,820.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,256,700.00	64,327,198.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,086,700.00	64,177,198.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	170,000.00	150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,538,246.41	20,327,439.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,538,246.41	20,327,439.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,038,246.41	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,500,000.00	20,327,439.60

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	-453,974,118.27
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	15,367,980.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	15,367,980.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	15,367,980.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	15,367,980.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-15,367,980.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	-469,342,098.27

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,501,291.24	219,531,571.15	110,765,832.79	661,798,695.18
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,501,291.24	219,531,571.15	102,566,144.67	653,599,007.06
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	331,501,291.24	219,531,571.15	110,765,832.79	661,798,695.18
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-8,199,688.12	-8,199,688.12
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	331,501,291.24	219,531,571.15	102,566,144.67	653,599,007.06
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	331,501,291.24	219,531,571.15	106,630,178.84	657,663,041.23
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	331,501,291.24	219,531,571.15	102,566,144.67	653,599,007.06
19	Тайлант үеийн үр дүн	0	0	4,064,034.17	4,064,034.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	502,642,600.00	469,460,098.27	469,460,098.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	502,642,600.00	469,460,098.27	469,460,098.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	502,642,600.00	469,460,098.27	469,460,098.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,629,500.00	332,911,187.35	332,911,187.35
210101	Үндсэн цалин	253,433,000.00	241,434,621.37	241,434,621.37
210102	Нэмэгдэл	94,196,500.00	91,031,558.98	91,031,558.98
210104	Урамшуулал	0	445,007.00	445,007.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,453,800.00	43,453,800.00	43,453,800.00
210201	Тэтгэврийн даатгал	29,548,500.00	29,548,500.00	29,548,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,476,300.00	3,476,300.00	3,476,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,781,100.00	2,781,100.00	2,781,100.00

210204	Ажилгүйдлийн даатгал	695,300.00	695,300.00	695,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,952,600.00	6,952,600.00	6,952,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,328,700.00	28,234,330.92	28,234,330.92
210301	Гэрэл, цахилгаан	2,651,100.00	2,761,394.92	2,761,394.92
210302	Түлш, халаалт	27,677,600.00	25,472,936.00	25,472,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,589,900.00	19,558,840.00	19,558,840.00
210401	Бичиг хэрэг	2,636,500.00	2,636,500.00	2,636,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,833,200.00	14,758,340.00	14,758,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,120,200.00	2,164,000.00	2,164,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,117,000.00	17,392,880.00	17,392,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,092,100.00	15,367,980.00	15,367,980.00
210604	Урсгал засвар	2,024,900.00	2,024,900.00	2,024,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,565,600.00	4,512,000.00	4,512,000.00
210702	Дотоод албан томилолт	4,565,600.00	4,512,000.00	4,512,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,689,700.00	70,474.00	70,474.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00	0	0
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	0	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	48,474.00	48,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	0	0
210807	Газрын төлбөр	138,300.00	0	0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	17,400.00	0	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,268,400.00	23,326,586.00	23,326,586.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,965,000.00	23,176,586.00	23,176,586.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	150,000.00	150,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	502,642,600.00	469,460,098.27	472,011,100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	472,011,100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	472,011,100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	456,550,500.00	469,460,098.27	0
320001	Орон нутгийн төсвөөс	456,550,500.00	469,460,098.27	0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	46,092,100.00	0	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	46,092,100.00	0	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0
610001	Төсвийн байгууллага	1	1	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	0
620001	Удирдах ажилтан	8	8	0
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0
620004	Гэрээт ажилтан	0	0	0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	20	0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	0

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4	0
650010	Гэрээт ажилтан	0	0	0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,688,051.60	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,688,051.60	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,360,612.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	360,000.00	
210402	Тээвэр, шатахуун	360,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,000,612.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,000,612.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,327,439.60	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,327,439.60	
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,327,439.60	
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,688,051.60	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,688,051.60	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,688,051.60	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд чиглэгдэнэ.

Тус байгууллага нь “Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх” гэсэн зорилгын хүрээнд 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 101 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлт 94.5 хувьтай үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Нягтлан

бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөхөөс гадна Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам бусад хууль, тогтоомж, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит болон аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,038.9 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	421.7	421.7
Бараа материал	34,491.5	36,024.4	1,532.9
Үндсэн хөрөнгө	619,132.6	621,216.9	2,084.3
Нийт хөрөнгө	653,624.1	657,663.0	4,038.9
Өр төлбөр	25.1	-	(25.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	653,599.0	657,663.0	4,064.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	653,624.1	657,663.0	4,038.9

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, үндсэн хөрөнгө дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, барилгын засварын материалын худалдан авалт их байсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 15,367.9 мянган төгрөгийн компьютер худалдан авсан, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн санхүүжилтээс худалдан авсан мотоцикл, бялдаржуулах тоног төхөөрөмжийн болон бусад тоног төхөөрөмжийн 43,042.5 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, тайлант оны элэгдлийн зардал зэрэгтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 404,032.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 31,092.1 мянган төгрөгөөр бууруулж, нийт 372,940.1 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 52,518.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн үндсэн болон баг хороо, мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нөөц хөрөнгө зэрэг 6 үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр 456,550.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 472,011.1 мянган төгрөгийн санхүүжилт, олгож, гүйцэтгэл 469,460.0 мянган төгрөг буюу 99.4 хувьтай бөгөөд үйл ажиллагааны орлого 2,669.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	362,906.1	360,645.6	2,260.5	99.4
2	80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	87,679.4	85,637.9	2,041.5	97.7
3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	0.0	0.0	0.0	0.0
4	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	23,086.5	-18,086.5	461.7
5	81701	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	965.0	90.0	875.0	9.3
		Дүн	456,550.5	469,460.0	-12,909.5	102.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр нийт 61.688.0 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 40,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газраас 1,478.8 мянган төгрөг, аймгийн Засаг даргаас 3,948.0 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 908.2 мянган төгрөг, сумын Орон нутгийн Хөгжлийн сангаас 15,353.0 мянган төгрөг бүрдсэн байна. Үүнийг сумын төвийн гэрэлтүүлэг, Галуутайн голын далан засварлах, малын түүвэр судалгаа, хамтарсан багийн зардал, далпуу татах, тэжээл хүргэх шатахуун, сургалт, томилолт зэрэгт зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас 20,327.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, төсөл хөтөлбөр гараагүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Сумын төвийн гэрэлтүүлэг	20,000.0	20,000.0
ДҮН			20,000.0	20,000.0

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэл, сангийн сайдын тушаал, журамтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсүвд аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03/24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт орлого 577,518.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,662.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,063.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй ч батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор (shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим санд оруулсан байдлыг анхан шатны баримт, мөнгөн гүйлгээний журналтай тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 7,730.0 мянган төгрөгийг мэдээлээгүй байна. Бусад мэдээллийг тухай бүр оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 337,526.2 мянган төгрөгийн зөрчилд 2 заалт зөвлөмж хүргүүлсэн бөгөөд 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	1,004.9	1	1,004.9	100
Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж	1	336,521.3	1	336,521.3	100
Нийт дүн	2	337,526.2	2	337,526.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,951.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 9,951.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Хандиваар ирсэн үндсэн хөрөнгийг үндсэн үнээс 9,951.0 мянган төгрөгөөр илүү тусгасан алдаа гаргасан байна. Энэ нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалтууд, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 63,199.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 47,831.4 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд албан шаардлага, 15,367.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны ажилтанд Засаг даргын Тамгын газраас ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 2,182.4 мянган төгрөг олгосон;

Нутгийн зөвлөлийн уулзалт, золголтод хүнсний материал 5,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан, техникийн комиссын дүгнэлтгүй 4,750.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан, аймгийн 100 жилийн ойд хандив өгсөн хүмүүст гарын бэлэг, дурсгалын зүйл 1,899.0 мянган төгрөгөөр худалдан авсан;

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжиж ирсэн сумын төвийн гэрэлтүүлгийн ажлын гэрээ хугацаандаа хийгдээгүй, тайлант онд 20,000.0 мянган төгрөгийн ажил хийгдсэн ч тодорхой үр дүн гараагүй;

Галуутайн голын гүүрний далан засах ажилд шууд гэрээ байгуулан 14,000.0 мянган төгрөгийг гэрээлэгчийн хувийн дансанд шилжүүлсэн ч холбогдох анхан шатны баримтгүй, тухайн ажил тайлант онд огт хийгдээгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрх бүхий байгууллагын шийдвэргүй 15,368.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан зөрчил илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.3-д "Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэдэг зөрчлийг арилгах;

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газрыг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, УСНББОУС 31 Биет бус хөрөнгө АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 заалтууд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газруудыг данс бүртгэлд тусгах арга хэмжээг авч ажиллах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 31-ний дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хандиваар ирсэн үндсэн хөрөнгийг илүү дүнгээр	1	9,951.0			1	9,951.0	1	9,951.0				
Дүн	1	9,951.0			1	9,951.0	1	9,951.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан туш	Тоо	Дүн
Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны ажилтанд Засаг даргын Тамгын газраас ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 2,182.4 мянган төгрөг олгосон;	1	2,182.40			1	2,182.40						
Нутгийн зөвлөлийн уулзалт, золголтод хүнсний материал 5,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан, техникийн комиссын дүгнэлтгүй 4,750.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан, аймгийн 100 жилийн ойд хандив өгсөн хүмүүст гарын бэлэг, дурсгалын зүйл 1,899.0 мянган төгрөгөөр худалдан авсан;	1	11,649.00			1	11,649.00						
Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжиж ирсэн сумын төвийн гэрэлтүүлгийн ажлын гэрээ хугацаандаа хийгдээгүй, тайлант онд 20,000.0 мянган төгрөгийн ажил хийгдсэн ч тодорхой үр дүн гараагүй;	1	20,000.00			1	20,000.00						
Галуутайн голын гүүрний далан засах ажилд шууд гэрээ байгуулан 14,000.0 мянган төгрөгийг гэрээлэгчийн хувийн дансанд шилжүүлсэн ч холбогдох анхан шатны баримтгүй, тухайн ажил тайлант онд огт хийгдээгүй байна	1	14,000.00			1	14,000.00						
Эрх бүхий байгууллагын шийдвэргүй 15,367.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан	1	15,368.00					1	15,368.00				
Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газрыг данс бүртгэлд тусгаагүй	1	0					1	0				
Дүн	6	63,199.40			4	47,831.40	2	15,367.90				


Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2024.02.22

АУДИТЫН МЕНЕЖЕР



Х.БОЛДБААТАР

2024.02.22

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Г.БААСАНЖАРГАЛ

2024.02.22